



**“НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ**

2023 оны 1 дүгээр
сарын 31 өдөр

№ 1


Улаанбаатар хот

**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ИРЦИЙН ТУХАЙ БОЛОН
ХУРЛЫГ ХҮЧИН ТӨГӨЛДӨРТ ТООЦОХ ТУХАЙ**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.1 дэх заалт,
69 дүгээр зүйлийн 69.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Хувьцаа эзэмшигчдийн энэ удаагийн хуралд 2'390'757 хувьцаа эзэмшдэг 44 хувьцаа эзэмшигч өөрийн биеэр, 23 хувьцаа эзэмшигч саналын хуудсаар оролцож нийт гаргасан энгийн хувьцааны 3'128'426 ширхэг буюу 60,09 хувь болж байгааг хуралд оролцогчид болон хурлын даргад мэдээлсүгэй.

2. Компанийн тухай хуулийн 69.1 дэх хэсгийн заалтыг үндэслэн нийт саналын эрхтэй энгийн хувьцааны 3'128'426 ширхэг буюу 60,09 хувийг эзэмшигчид оролцож байгаа учраас компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг хүчин төгөлдөрт тооцсугай.

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА  М.ОТГОНБААТАР



**“НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТООЛЛОГЫН КОМИССЫН ТОГТООЛ**

2023 оны 1 дүгээр
сарын 31 өдөр

№ 2

Улаанбаатар хот

САНАЛ ХУРААХ ХУУДСЫГ ТООЛСОН ДҮНГИЙН ТУХАЙ

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.2 дах заалт, санал хураах хуудсаар өгсөн саналыг тоолсон дүнг хэлэлцээд **ТОГТООХ НЬ:**

1.

№	Хэлэлцэх асуудал	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн	Хувь
1	Хувьцаа хуваах тухай	3,128,426			100%
2	Нэмэлт хувьцаа гаргах тухай	3,128,426			100
3	ТУЗ-ийн зардлыг батлах тухай	3,128,426			100
4	Төсөл, хөтөлбөрүүдийг оновчтой зохион байгуулах талаарх ТУЗ-аас гаргасан саналыг хэлэлцэх, шийдвэрлэх тухай	3,128,426			100
5	ТУЗ-ийн үйл ажиллагааны журам	3,128,426			100
6	Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай	3,128,426			100

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА

М.ОТГОНБААТАР



**“НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 1 дүгээр
сарын 31 өдөр

№ 1

Улаанбаатар хот

ХУВЬЦАА ХУВААХ ТУХАЙ

“Санал хураах хуудсыг тоолсон дүнгийн тухай” тооллогын комиссын 02 тоот тогтоол, Компанийн тухай хуулийн 51, 62 дахь зүйл заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Ногоон хөгжил үндэсний нэгдэл” хувьцаат компанийн нэг бүр нь 1 төгрөгийн нэрлэсэн үнэтэй нийт гаргасан 5,205,600 ширхэг энгийн хувьцааны нэгж хувьцаа бүрийг 100 хувааж нэг бүр нь 1 мөнгөний нэрлэсэн үнэтэй нийт 520,560,000 ширхэг хувьцаа болгон хуваасугай.
2. Хувьцаа хуваахтай холбогдуулан компанийн дүрэм дэх нийт зарласан хувьцааг 100,520,560,000 ширхэг болгон нэмэгдүүлсүгэй.
3. Хувьцаа хуваахтай холбогдуулан “Хувьцаа хуваах үйл ажиллагааг гүйцэтгэх журам”-ийг 01-р хавсралтаар, “Хувьцаа хуваах төсөл”-ийг 02-р хавсралтаар баталсугай.
4. Энэхүү тогтоол гарж байгаатай холбогдуулан “Ногоон хөгжил үндэсний нэгдэл” хувьцаат компанийн дүрмийн төслийг 03-р хавсралтаар өөрчлөн найруулахыг зөвшөөрсүгэй.
5. Санхүүгийн зохицуулах хорооноос Хувьцаа хуваах шийдвэрийн зөвшөөрөл гармагц Компанийн дүрмийн төслийн өөрчлөлтийг Улсын бүртгэлийн газраар батлуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (Ж.Жаргалсайхан)-д даалгасугай.
6. Энэхүү тогтоолын биелэлтийг хангаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (Ж.Жаргалсайхан)-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Ж.ЖАРГАЛСАЙХАН



**“НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 1 дүгээр
сарын 31 өдөр

№ 2

Улаанбаатар хот

“НЭМЭЛТ ХУВЬЦАА ГАРГАХ ТУХАЙ”

“Санал хураах хуудсыг тоолсон дүнгийн тухай” тооллогын комиссын 02 тоот тогтоол, Компанийн тухай хуулийн 32.3 дахь зүйл заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Санхүүгийн Зохицуулах Хорооны зөвлөмж 2022 оны 07 сарын 04-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаас хойш үүссэн нөхцөл байдлыг харгалзан үзэж тус хурлаар хэлэлцсэн (2) тоот тогтоолоор баталгаажуулсан нэмэлт хувьцаа гаргах асуудлыг хувьцаа хуваах төслөөс тусад нь хэлэлцэхээр шийдвэрлэсүгэй.
2. Нэмэлт хувьцаа гаргах асуудлыг 2023 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (Ж.Жаргалсайхан)-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Ж.ЖАРГАЛСАЙХАН



**“НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 1 дүгээр
сарын 31 өдөр

№ 7

Улаанбаатар хот

КОМПАНИЙН ДҮРЭМД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

“Санал хураах хуудсыг тоолсон дүнгийн тухай” тооллогын комиссын 02 тоот тогтоол, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Хувьцаа хуваахтай холбогдуулан Компанийн дүрмийн 4.1 заалтыг “нийт зарласан хувьцаа 100,520,560,000 ширхэг байна. Энэ дүрмийг батлах байдлаар компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 5,205,600 төгрөг байна. Нийт зарласан хувьцааны 70,520,560,000 ширхэг нь 1 мөнгөний нэрлэсэн үнэтэй энгийн хувьцаа байна. Үүнээс гүйлгээнд гаргасан энгийн хувьцаа 520,560,000 ширхэг байна. нийт зарласан хувьцааны 30,000,000,000 ширхэг нь давуу эрхийн хувьцаа байна. Нэгжийн үнийг Төлөөлөн удирдах зөвлөл тогтооно” гэж нэмэлт өөрчлөлт оруулсугай.
2. Дүрмийн өөрчлөлтийг хууль заасан хугацаанд эрх бүхий байгууллагад хүргүүлэх, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал (Д.Санжаа)-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Ж.ЖАРГАЛСАЙХАН



**“НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 1 дүгээр
сарын 31 өдөр

№ 4

Улаанбаатар хот

**ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРҮҮДИЙГ ОНОВЧТОЙ ЗОХИОН БАЙГУУЛАХ
ТАЛААРХ ТУЗ-ААС ГАРГАСАН САНАЛЫГ ХЭЛЭЛЦЭХ,
ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ**

“Санал хураах хуудсыг тоолсон дүнгийн тухай” тооллогын комиссын 02 тоот тогтоол, Компанийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1, 22 дугаар зүйл, 62 дугаар зүйлийн 62.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ**:

1. Компанийн үйл ажиллагааг зогсоохгүйгээр түүний зарим эрх, үүрэг, хариуцлагыг шинээр байгуулагдах компанид шилжүүлэх замаар тус компанийн 100 хувийн эзэмшлийн охин компанийг үүсгэн байгуулж зарим үйл ажиллагааг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (Ж.Жаргалсайхан)-д даалгасугай.
2. Ногоон хөгжил үндэсний нэгдэл ХК-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон санхүүгийн тайланд үндэслэн Хувьцаат орон сууц хөтөлбөрийн үйл ажиллагаанд хамаарах хөрөнгө, авлага, өр төлбөрийг шинээр үүсгэн байгуулагдах охин компанид шилжүүлэхийг Гүйцэтгэх захирал (Д.Санжаа)-д зөвшөөрсүгэй.
3. Компанийн хуваах баланс, тусгаарлах замаар үүсгэн байгуулагдах охин компанид шилжүүлэх хөрөнгийн жагсаалт, шилжүүлэх өглөг, авлагыг багтаасан “Өөрчлөн байгуулах төсөл”-ийг (1) дүгээр Хавсралтаар баталсугай.
4. Шинээр байгуулах охин компанийн үүсгэн байгуулах хурлыг зохион байгуулж, хувь нийлүүлсэн хөрөнгийг тогтоох, дүрэм батлах, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох асуудлыг хэлэлцүүлэх арга хэмжээ авах бүрэн эрхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн хурал, ТУЗ-ийн дарга (Ж.Жаргалсайхан)-д олгосугай.
5. Хөтөлбөрийг тусгаарлах замаар өөрчлөн байгуулсантай холбоотойгоор компанийн санхүүгийн завсрын тайлан гаргаж, зохих журмын дагуу эрх бүхий байгууллагад хүргүүлж баталгаажуулах, шинээр үүсгэн байгуулагдаж байгаа компанийн гүйцэтгэх удирдлагад тусгаарласан хөрөнгө, өглөг, авлагын тооцоог нэг бүрчлэн, шаардлагатай бол бичгээр үйлдсэн тайлбарын хамт акт үйлдэн зохих ёсоор хүлээлгэн өгөхийг Гүйцэтгэх захирал (Д.Санжаа)-д үүрэг болгосугай.

6. 2023 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хөрөнгө, өглөг, авлагын тооцоог нэг бүрчлэн хийж тусгаарлах замаар үүсгэн байгуулагдах охин компанид зохих ёсоор хүлээлгэн өгөх өдөр хүртэл тасралтгүй үргэлжлүүлэн өгөхийг Гүйцэтгэх захирал (Д.Санжаа)-д үүрэг болгосугай.
7. Хувьцаат орон сууц хөтөлбөрийн үйл ажиллагааг тусгаарлахтай холбогдуулан төслийн хүрээнд харилцагчтай байгуулсан гэрээ, хэлцлийн эрх, үүрэг шилжих тул уг гэрээ, хэлцэлд нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэн байгуулах, эд хөрөнгийг актаар хүлээн авах, төсөл хөтөлбөртэй холбогдуулан давуу эрхийн хувьцаа гаргах зэрэг шаардлагатай арга хэмжээг богино хугацаанд, шуурхай авахыг тусгаарлах замаар үүсгэн байгуулагдах охин компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, Гүйцэтгэх захирал, “Ногоон хөгжил үндэсний нэгдэл” ХК-ийн Гүйцэтгэх захирал (Д.Санжаа)-д тус тус үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Ж.ЖАРГАЛСАЙХАН



**“НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 1 дүгээр
сарын 31 өдөр

№ 5

Улаанбаатар хот

**“ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ЖУРАМ”-ЫГ ХЭЛЭЛЦЭН БАТЛАХ ТУХАЙ**

“Санал хураах хуудсыг тоолсон дүнгийн тухай” тооллогын комиссын 02 тоот тогтоол, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.12 дахь заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн (ТУЗ) 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 02 тоот тогтоолд Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцүүлэхээр дурдсан “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ыг батлах асуудал нь Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13-т зааснаар Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрхэд хамаарч байх тул Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын хэлэлцэх асуудлаас хасаж, Төлөөлөн Удирдах Зөвлөл баталсугай.
2. “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ын төслийг компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар батлуулахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (Ж.Жаргалсайхан)-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Ж.ЖАРГАЛСАЙХАН



**“НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 1 дүгээр
сарын 31 өдөр

№ 6

Улаанбаатар хот

КОМПАНИЙН ДҮРЭМД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

“Санал хураах хуудсыг тоолсон дүнгийн тухай” тооллогын комиссын 02 тоот тогтоол, Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2020 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 02 дугаар тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулан баталсан “Ногоон хөгжил үндэсний нэгдэл” нээлттэй хувьцаат компанийн дүрэм (“Компанийн дүрэм” гэх)-ийн 7.6 дахь хэсгийн “хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонхын саналаар” гэснийг “хувьцаа эзэмшигчдийн саналын дийлэнх олонхоор” гэж, мөн дүрмийн 7.7 дахь хэсгийн “хувьцаа эзэмшигчдийн олонхын саналаар” гэснийг “хувьцаа эзэмшигчдийн саналын олонхоор” гэж тус тус өөрчилсүгэй.
2. Компанийн дүрмийн 7.31.21-ийг “Хараат болон охин компани, салбар, төлөөлөгчийн газар байгуулах, тэдгээрийн эрх хэмжээ, үйл ажиллагааны чиглэлийг тогтоох, өөрчлөх болон хувьцаа эзэмшигчийн эрх, үүргийг хэрэгжүүлэх” гэж өөрчлөн, 7.3.22-д “хувьцаа эзэмшигчдийн хурлаас эрх олгосон бусад асуудал” гэж нэмсүгэй.
3. Дүрмийн өөрчлөлтийг хууль заасан хугацаанд эрх бүхий байгууллагад хүргүүлэх, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал (Д.Санжаа)-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Ж.ЖАРГАЛСАЙХАН



**“НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТОГТООЛ**

2023 оны 1 дүгээр
сарын 31 өдөр

№ 7

Улаанбаатар хот

КОМПАНИЙН ДҮРЭМД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

“Санал хураах хуудсыг тоолсон дүнгийн тухай” тооллогын комиссын 02 тоот тогтоол,
Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн
ТОГТООХ НЬ:

1. Хувьцаа хуваахтай холбогдуулан Компанийн дүрмийн 4.1 заалтыг “нийт зарласан хувьцаа 100,520,560,000 ширхэг байна. Энэ дүрмийг батлах байдлаар компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ 5,205,600 төгрөг байна. Нийт зарласан хувьцааны 70,520,560,000 ширхэг нь 1 мөнгөний нэрлэсэн үнэтэй энгийн хувьцаа байна. Үүнээс гүйлгээнд гаргасан энгийн хувьцаа 520,560,000 ширхэг байна. нийт зарласан хувьцааны 30,000,000,000 ширхэг нь давуу эрхийн хувьцаа байна. Нэгжийн үнийг Төлөөлөн удирдах зөвлөл тогтооно” гэж нэмэлт өөрчлөлт оруулсугай.
2. Дүрмийн өөрчлөлтийг хууль заасан хугацаанд эрх бүхий байгууллагад хүргүүлэх, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт бүртгүүлэхийг Гүйцэтгэх захирал (Д.Санжаа)-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Ж.ЖАРГАЛСАЙХАН